

“Оллоо” ХК-ий 2015 оны ТУЗ-ийн

ээлжит хурлын протокол

2015.02.27

Улаанбаатар хот

“Оллоо” ХК-ий ТУЗ-ийн ээлжит хурал 2015.02.27 –ний өдөрийн 16.00 цагаас “Оллоо” ХК-ий байранд болохоор товлогдсон.

Хуралд ТУЗ-ийн дарга П.Бүүвэйбаатар, Гүйцэтгэх захирал Р.Цагаанган, нягтлан бодогч Г.Гоёцэцэг нар байв. Компаний дүрмэнд заасны дагуу ТУЗ-ийн гишүүн Хатуутөмөр, Батжин /Нармандахын оронд түр/, Эрдэнэжав, Батчимэг, Батбаяр нар мэйлээр болон бичгээр саналаа өгсөн.

Бүүвэйбаатар: Хурлын ирц 9 гишүүнээс 1 гишүүн ирсэн, 5 гишүүн саналаа өгсөн, нийт 6 гишүүний ирцтэй тул хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзэх нь зүйтэй.

Хурлаар дараахи асуудлуудыг ярилцаж шийдвэрлэнэ:

1. 2015 оны ажлын төлөвлөгөө
2. 2014 оны үйл ажиллагааны тайлан ба санхүүгийн тайлан
3. СЗХ-ноос компаний үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээнүүд
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах

Р.Цагаанган: 2015 оны ажлын төлөвлөгөө

1. Вэб сайтаа бүрэн шинэчилж дуусгах, App хийх
 2. Контент борлуулах
 3. Онлайн худалдаа эрхлэх
 4. Мэдээний бичлэгийн чанар сайжруулах, сайтын хандалтыг нэмэгдүүлэх
- Вэб сайтаа бүрэн шинэчилж дуусгах, App хийх

2014 онд манай хамт олон Вэбийнхээ ерөнхий төрхийг өөрчилж, шинэлэг, содон, үзэмжтэй болгож дан ганц мэдээллийн сайт биш, мэдээлэл интертаймэнт, контент хосолсон сайт болох зорилтыг тавин ажилласан. Энэхүү зорилтын дагуу 2014 оны 5 сарын 7 – ны өдөр Оллоо веб сайтын 5-р хувилбар ашиглалтанд орж веб сайт маань бүрэн шинэчилэгдсэн. Энэ шинэ веб нь технологийн дэвшилтэт боломжуудыг бүрэн ашигласан бөгөөд мэдээний хурдан шуурхай байдал, бүх дэлгэцэнд уян хатан харагдах нөхцөл мөн веб сайтын хандалтын тоо өссөн эерэг үзүүлэлтэйгээр ажиллаж байна. Вэбийн ашиглалтын явцад засаж сайжруулах ажлууд гарж байгаа бөгөөд эдгээр засваруудыг 2015 оны 2-р сардаа багтаан дуусгах зорилт тавин ажиллаж байна.

Мөн энэ онд Apple, Android утсанд зориулсан Application хийж ашиглалтанд оруулна.

- Контент борлуулах

Одоо ажиллаж байгаа, Оллоо гишүүнчлэлийн системийг ашигласан контент борлуулах үйлчилгээг улам өргөжүүлэн мэдээ, видео мэдээ, бүх төрлийн контентийг интернет хэрэглэгчидэд төлбөртэйгээр борлуулна.

- Онлайн худалдаа эрхлэх

Бүх төрлийн бараа тэр дундаа сонин содон анхаарал татахаар, хүний хэрэгцээг хангахуйц, үнийн хувьд боломжийн барааг судлан веб сайтаараа сурталчилан борлуулах, үнэгүй хүргэлт хийх үйлчилгээг судлан нэвтрүүлнэ. Цаашдаа бусад бизнесийн байгууллагууд ба хувь хүний бараануудыг худалдан борлуулж, борлуулалтын хувь аван орлого олох боломжтой.

- Мэдээний бичлэгийн чанар сайжруулах, веб сайтын хандалтыг нэмэгдүүлэх

Сэтгүүлчидийнхээ ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төрөл бүрийн салбараар дагнасан сэтгүүлчидийн мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.

Гадаад хэлний орчуулгын мэдээний чанарт анхааран ажиллаж, өөр хэвлэл мэдээлэлд орчуулагдаагүй шинэ содон мэдээг орчуулж уншигчидад хүргэнэ.

Их, дээд сургуулийн сэтгүүл зүйн ангийн оюутнуудын дунд нийтлэлийн нээлттэй уралдаан зохион байгуулах ба амжилттай оролцсон оюутануудад ажлын санал тавьж мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Шалгарсан нийтлэлүүдийг цувралаар веб сайтдаа байршуулна.

Өнөөдрийн байдлаар olloо.mn веб сайт нь Монгол сайтууд дундаа хандалтаараа эхний 2-3 байранд орж байгаа ба өдөрт /давхардаагүй тоогоор/ 40 000 орчим хэрэглэгч манай сайтад хандаж байна.

Гоёцэцэг: 2014 оны үйл ажиллагааны тайлан ба санхүүгийн тайлан

“ Оллоо ХК ” 2014 оны байдлаар нийт 113,653,266.59 төгрөгийн орлого , 217,155,014.36 төгрөгийн зардал , (103,491,220.08) төгрөгийн алдагдалтай ажилсан байна. Компаний нийт хөрөнгийн хэмжээ 284,717,078.78 төгрөг байна.

Цагаанган: Санхүүгийн Зохицуулах Хорооноос компаний үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээнүүд: Үүнд:

1. Хороонд хөтлөгдөж буй Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр худалдахыг зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд “Оллоо” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 9,700,497 ширхэг энгийн хувьцааг бүртгэсэн бөгөөд Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 970,049,700 төгрөг байна. Харин “Оллоо” ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,005,600.0 мянган төгрөг гэж зөрүүтэй тусгасан тул улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгэн 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор тус Хороонд ирүүлэх;
2. Хороонд бүртгэлтэй үнэлгээний байгууллагаар хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх;
3. “Оллоо” ХК-ийн хувьд Хороонд хөтлөгдөж буй үнэт цаасны бүртгэлд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 9,700,497 ширхэг хувьцаа гаргасан буюу 970,049,700

төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй гэж бүртгэгдсэн байгаа бөгөөд 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өөрийн хөрөнгийн хэмжээ 372,079,645.50 төгрөг гэж тусгагдсан байгаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тул Компанийн тухай хуулийн 31.3 дах хэсэгт заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэх;

4. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хороодыг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгуулах;
5. Компаний тухай хуулийн 97 дугаар зүйлд заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээллийг хөтөлж, уг мэдээллийг 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор тус хороонд ирүүлэх;
6. Компанийн тухай хуулийн 75.8 дах хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамруулж гэрчилгээний хуулбарыг тус Хороонд ирүүлэх;
7. Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан ниитэд мэдээлэх;
8. Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийн мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг зохицуулах дотоод журмыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулж уг журмын хуулбарыг 2015 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор тус Хороонд ирүүлэх;

Бүүвэйбаатар: “Оллоо” ХК-ий 2015 оны ХЭХурал хуралдуулах төлөвлөгөө

- 2015.04.27 /Даваа гариг/ - 16.00 цагт ХЭХурал хуралдана

Компаний тухай хуулийн 60.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

- Хувьцаа эзэмшигчид 2015.04.13-ны өдрөөс эхлэн харьяа брокер дилерийн компаниасаа хурлын материал авж танилцана
- 2015.03.13 /Баасан гариг/- Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр

Компаний тухай хуулийн 64.2 Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь тухайн хурал хуралдах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө байна.

- 2015.03.03; 2015.03.17 /Мягмар гариг/ - Өдөр тутмын сонинд хурлын зарыг хэвлэнэ

Компаний тухай хуулийн 60.4 Компани энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн хэвлэл

мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй.

- 2015.02.27 /Баасан гариг/ - ТУЗ хуралдан шийдвэрээ гаргана.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компаний 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компаний 2015 оны ажлын төлөвлөгөө
3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчилөн томилох асуудал
4. Компаний гэрчилгээнд өөрчлөлт оруулах
5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгөжүүлэх асуудал

Хатуутөмөр: Өнөөдөр зарлагдсан хуралд очиж амжихгүй тул саналаа энэхүү мэйлээр баталгаажуулж байна.

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу дараах саналууд байна.

1. 2014 үйл ажиллагаа – Санхүүгийн тайлангаас харахад 2014 онд тус компани нь орлого нэмэгдүүлэх, цаашлаад үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон идэвхжүүлэх тал дээр хангалтгүй ажилласан харагдаж байна. Хэдийгээр эдийн засгийн байдал сайнгүй байсан нь компанийн зар сурталчилгаанаас олох гол орлогод нөлөөлсөн байх боловч шинээр бүтээгдхүүн үйлчилгээ санаачлах болон харилцагч мөн цахим салбарын бусад ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгчдтэй харьцуулбал идэвхигүй унтаа байдалтай өнгөрүүлээ гэж дүгнэж байна.
2. 2015 оны төлөвлөгөөний талаар
 - Вэб сайтаа бүрэн шинэчилж дуусгах, App хийх ,
 - Контент борлуулах
 - Онлайн худалдаа эрхлэх
 - Мэдээний бичлэгийн чанар сайжруулах, сайтыг хандалтыг нэмэгдүүлэх

Дээрхээс харвал контент борлуулах, App хийхээс бусад нь урд өмнөх жилүүдэд мөн хийгдэж байсан ажлууд бөгөөд Цахим салбарын дундах байр сууриа хадгалах болон цаашид компанийн хувьд хөгжихийн тулд дээрхээс гадна шинэлэг, хүртээмжтэй, хандалтын тоонд нөлөөлөхүйц бичлэгийн болон цахим хуудасны цоо шинэ хэлбэрээр ажиллах нь чухал байна. Үүнд: Оллоо хуудасны үндсэн жанр-ийг тодорхой болгох - / мэдээ, мэдээллийн; энтертайн; видео, контент гэх мэт/

Хэлбэрийн хувьд шинэлэг , өвөрмөцөөр илэрхийлэх – олон нийтийн сүлжээний бусад цахим хуудасуудтай холбоотой ажиллах

3. СЗХ-ны шалгалтын мөрөөр хийх ажил – Гол анхаарал татсан асуудал нь Өөрийн хөрөнгийн харьцаа алдагдсан тухай байна. Энэ тал дээр хөрөнгө оруулагчдын санал бодлыг сонсож нэгдсэн нэг ойлголттой болох нь зөв гэж бодож байна. Тодорхой хугацаа товлоод ТУЗ-ийг дахин хуралдуулж асуудлыг шийдвэрлэх нь зөв.
4. Хурал зарлан хуралдуулах
5. ТУЗ-ийн гишүүн Д.Нармандах ажилаас чөлөөлөгдсөн тул тус компанийн Шинжээч ажилтай Н.Батжинг нөхөн сонгох саналтай байна.

Батжин: Миний бие хуралд биеэр очиж оролцох боломжгүй байгаа тул саналаа энэхүү емэйлээр өгч байна.

Үйл ажиллагаа, Санхүүгийн тайлантай танилцаж үзсэний үр дүнд ерөнхий болон удирдлагын зардал их байгаа нь компани алдагдалтай ажиллахад хүргэжээ, гэвч санхүү эдийн засгийн өнөөгийн нөхцөлтэй харьцуулахад Компанийн 2014 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан хангалттай гэж үзэж байна.

2015 онд хийх ажлын төлөвлөгөөтэй танилцах явцад мэдээ контентийн чанар дээр анхаарах гэдэг зүйл дээр маш их санал нийлж байна. Цаашлаад онлайн худалдааг нэвтрүүлэх тал дээр ажиллах нь цаг үетэйгээ нийцсэн зөв алхам юм. Харин application

хийх явц удаан байгаад шүүмжтэй байна. Тиймээс 2015 оны ажлын төлөвлөгөөг дэмжиж байна.

СЗХ-ноос тавьсан шаардлагуудыг дагаж, зохих арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй юм. Үүнд Улсын Бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах, компанийн хөрөнгийг болон санхүүгийн тайланг СЗХ-нд бүртгэлтэй үнэлгээний байгууллагаар үнэлүүлж дүгнэлтийг зарлуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх тал дээр анхаарах зэрэг ажилууд багтана.

Эцэст нь СЗХ-ны 1 сарын 29-нд гаргасан зөвлөмжийг мөрдлөг болгож Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг 4 сарын эхний 2 долоо хоногт багтааж хуралдуулах санал тавьж байна.

Батчимэг: Б.Батчимэг миний бие нь 2015 оны 02 дугаар сарын 27 ны өдрийн ТУЗ-ийн хуралд биеэр оролцох боломжгүй болсон тул хуралд хэлэлцэх бүх асуудлуудыг санал нэгтгэйгээр дэмжиж, батлаж байгаагаа мэдэгдэж байна.

Эрдэнэжав: Хурлын зар, тайлан, төлөвлөгөөг уншиж танилцлаа.

2015 оны 2-р сарыг 1- ээс Н. Эрдэнэжав миний бие ЗТЯ-ны харьяа АТҮТ-д ажилд орсон тул Оллоо ХК-ийн ТУЗ-ын гишүүнээс чөлөөлж өгнө үү.

Батбаяр: Хурлын материалуудтай танилцлаа. 2014 оны санхүүгийн тайлантай танилцлаа. 2015 оны ажлын төлөвлөгөөг уншиж танилцлаа, дэмжиж байна, улам илүү сайн ажиллаарай. СЗХ-ны тавьсан бүх шаардлагуудыг биелүүлж ажиллах нь зүйтэй. ХЭХ-ийг төлөвлөгөөний дагуу хуралдуулахыг дэмжиж байна.

Бүүвэйбаатар: Гишүүдийн саналыг уншиж танилцаад дарахи шийдвэрүүдийг гаргая.

1. Компаний 2014 оны үйл ажиллагааны ба санхүүгийн тайланг хангалттай гэж үзлээ
2. Санхүүгийн Зохицуулах Хорооноос компаний үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээнүүдийг зохих журмын дагуу авч хэрэгжүүлье
3. ХЭХ-ийг гаргасан төлөвлөгөөний дагуу хуралдуулахаар тогтлоо



Handwritten signature of P. Bueibaatar

П.БҮҮВЭЙБААТАР
Г.ГОЁЦЭЦЭГ